

## ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ХӨНДИЙ АЛТНЫ ДҮҮРГИЙН ХАЙГУУЛ, ТЕХНИКИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ

### Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа, Халифакс хот  
2019.11.06

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь өөрийн 100% эзэмшлийн Хөндий Алтны Төслийн 2019 оны хоёрдугаар шатны өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулж, 2019 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөр эхэлж буйг мэдээлэхэд таатай байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Бид хайгуулын хөтөлбөрөөр Баян Хөндий ордын хязгаараас гадна өрөмдлөг хийснээр эрдэсжсэн бүсээ тэлэхийн зэрэгцээ Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Хар Морь (“Dark Horse”) хэмээх шинэ талбайг нээн илрүүлж, Хөндий Алтны Дүүргийн боломж үргэлжилж буйг бататгалаа. 2015 оноос хойш Эрдэнэ Ресурсийн илрүүлж буй эдгээр нээлтүүд нь Хөндий дүүргийн үр шимийг тодорхойлон харуулсаар байна”.

“2019 оны эцсийн хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөр нь энэ долоо хоногт эхэлж байгаа бөгөөд үүнд: Улаан тусгай зөвшөөрлийн талбайг өрөмдөх, саяхан шинээр илрүүлсэн Хар Морь талбайд нэмэлт хайгуул хийх болон геотехник, металлургийн судалгаа багтаж байгаа болно. Эрдэнэ Ресурс нь 2021 онд алтны үйлдвэрлэлээ эхлэхээр төлөвлөж байгаа ба Хөндий Алтны Дүүргийн өнөөг хүртэл бүрэн судлагдаагүй боломжууд нь цаашид биднийг хайгуул хийж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх чухал хүчин зүйл болно гэдэгт итгэж байна.”

### Хайгуулын үр дүнгийн онцлох мэдээ, 4-р улирлын төлөвлөгөө:

- > **Өмнөд Баян Хөндийн үргэлжлэл:** Баян Хөндий ордоос өмнө зүгт 350 метрт өрөмдлөг хийсэн бөгөөд үүнд өндөр агуулга бүхий Баян Хөндийн алтны ордтой адил шинж чанар бүхий галт уулын нэгдлийн хувирал бүхий алтны эрдэжилт огтолсон.
- > **Хар Морь** нь Баян Хөндий ордоос хойд зүгт 4.5 км-т Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 32.9 г/т алтны агуулга бүхий чулуулгийн дээж авснаар шинээр нээн илрүүлсэн бүс юм.
- > **Баян Хөндий – Страйкер ба Мидфийлд бүс:** BKD-269 цооногт хийсэн нарийвчилсан өрөмдлөгөөр 2.4 г/т алтны агуулга бүхий 32 метрийн интервал, BKD-270 цооногт хийсэн өрөмдлөгөөр 1.7 г/т алтны агуулга бүхий 37 метр интервал огтолж, Баян Хөндий ордын эрдэжилт үргэлжилж байгааг тодорхойллоо.
- > **11 сард эхлэх Улаан зэсийн талбайд хийх өрөмдлөг:** Зэсийн ахиу агуулгатай кварц-пиритийн зэрэгцээ штокверк судлуудыг огтолсон бүсээс доош өрөмдлөгийн судалгаа хийх бөгөөд филлик хувирал болон соронзон нягтралын судалгааг хийж гүйцэтгэнэ.

**Хойд Хөндий ба Төв Структурын Бүсийн үр дүн:** Хойд Хөндийд гүндээ кварцын штокверк болон брекчийн хувирсан монзонит огтолсныг бататгаж, Төв Структурын Бүсэд сульфидээр баялаг, хувирсан галт уулын нягт үелсэн чулуулаг оршиж байгааг тогтоосон.

### Хөгжүүлэлтийн онцлох мэдээ, 4-р улирлын төлөвлөгөө:

- > **Усны нөөц тодорхойлсон:** Усны ашиглалтын нөөцийг тодорхойлох зорилгоор Баян Хөндийн уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийг дэмжих боломжтой усны нөөцийн 6 цооногийг өрөмдсөн.

- > **11 сард эхлэх геотехникийн өрөмдлөг:** Өрөмдлөгөөр ил уурхайн ханын налуугийн тогтвортой байдлыг шалгах бөгөөд үүний үр дүн нь эцсийн ТЭЗҮ-д орох хөрс хуулалтын харьцааг бууруулах боломжтой.
- > **Металлургийн судалгаа:** Эцсийн ТЭЗҮ-д багтах боловсруулалт болон бутлагдах чанарыг баталгаажуулах зорилготой.

#### Өмнөд Баян Хөндий

2-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөр Баян Хөндий ордын нөөцийн хязгаараас гадна өмнө зүгт 264 метрийн гүнд өндөр агуулга бүхий алт (51.9 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал) огтолсон. Энэ шинэ нээлтээс өмнө зүгт үргэлжлүүлэн судалгаа хийсэн бөгөөд энэхүү хувирсан бүс нь өмнө зүгт 500 метрт геофизикийн судалгаагаар газрын гадаргад ойр гэдгийг тодорхойлсон. 3-р улирлын өрөмдлөгтэй зэрэгцэн (BKD-269) Баян Хөндий ордтой адил 100 метр нягт үелэн хувирсан галт уулын туфыг огтолсон бөгөөд 100 метрийн гүнд алт агуулсан туф нь 2.45 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон. Энэхүү нээлтээр ордын өмнө зүгт нэмэлт хайгуул хийж, эрдэсжсэн бүсийг тэлэх боломжтойг харуулж байна.

#### Шинээр илрүүлсэн Хар Морь бүс

Баян Хөндий ордоос хойш 4.5 км, Хөндий тусгай зөвшөөрлийн талбай дахь Алтан Арроу бүсээс зүүн өмнө зүгт 1 км-т чулуулгийн дээжийн судалгаа хийснээр 32.9 г/т алтны агуулга тогтоогдож, урьд нь судлагдаагүй талбайд (шинэ Хар Морь талбай) хайгуул хийсэн. Алт агуулсан дээж нь кварцын судал, штокверк агуулсан том хэмжээний турмалины бүсэд хамаарагдаж байна. 32.9 г/т алтны агуулга илрүүлсэн цэгээс баруун зүгт 500 метрт нэмэлт дээжлэлт хийж, 8.4 г/т алтны агуулга илрүүлснээр ирээдүйд хайгуул хийх боломжит хэтийн төлөв бүхий талбайг тодорхойллоо. Хэдийгээр энэхүү бүс нь хайгуулын анхан шатандаа байгаа боловч Баян Хөндий ордод ойр, урьд нь хайгуул хийгдэж байгаагүй, газрын дөт гүнд өндөр агуулгатай хүдэржилт байх боломжтой зэрэг нь сонирхол татаж байна. Ирэх долоо хоногуудад хөрсний болон чулуулгын сорьцлолт, геологийн зураглалын хөтөлбөрийг гүйцэтгэснээр алтны эрдэсжилт үргэлжилж буйг шалгах цаашдын өрөмдлөгийг тодорхойлно.

#### Баян Хөндийн нарийвчилсан өрөмдлөг

2019 оны 3-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөр Страйкераас Мидфийлд бүсийн дунд хоёр цооног өрөмдсөн нь энэхүү бүс дэх нөөцийг бататгах зорилготой байлаа. Өрөмдлөгийн үр дүнд хэд хэдэн өндөр агуулга илрүүлснээс BKD-269 цооноогоор 2.4 г/т алтны агуулга бүхий 32 метрийн интервал огтолсон, үүнд: 6.6 г/т алтны агуулга бүхий 6.4 метр интервал багтаж байна. BKD-270 цооноогоор 1.7 г/т алтны агуулга бүхий 37 метрийн интервал огтолсон, үүнд: 4.7 г/т алтны агуулга бүхий 7 метр интервал багтаж байна. Үр дүнгийн хураангуйг Хүснэгт 1-т харуулав.

#### Хүснэгт-1: Баян Хөндийн өрөмдлөгийн үр дүнгийн хураангуй

Цооног	(м) эхлэл	(м) хүртэл	Интервал (м)*	Алт (г/т)
<b>BKD-269</b>	<b>37</b>	<b>40</b>	<b>3</b>	<b>8.33</b>
үүнд	38	39	1	17.6
Ба	61	75	14	1.31
Ба	142	190	48	1.89
Үүнд	151	152	1	17.6
Үүнд	175.7	182	6.3	6.56
үүнд	181	183	1	32.9
<b>BKD-270</b>	<b>47</b>	<b>55</b>	<b>8</b>	<b>0.95</b>
Ба	139	176	37	1.68
Үүнд	165	172	7	4.74
үүнд	171	172	1	13.7

\* Судлын хазайлт ба өрмийн хазайлтад тулгуурласан интервалын бодит зузаан нь дунджаар 92% байна.

### Улаан зэсийн талбай

Улаан зэс порфирын боломжит талбайг 2018 оны эцсээр 350 метрийн босоо гүнд гурван өргөн цооног өрөмдөн судалж байсан. Эдгээр цооногууд нь пиритийн олон концентрац, бага хэмжээний зэсийн эрдэсжилт бүхий пропилитаас филлит кварц-серицитийн пиритийн (QSP) бүхий галт уулын чулуулаг огтолсон. UDH-02 нь хамгийн өндөр үр дүнг харуулсан бөгөөд штокверк кварц-пиритийн судлаар хучигдсан, өссөн зэсийн утга илэрсэн (60 метрийн турш 100-300 ppm). UDH-02 нь мөн гүндээ агриллитаас филлитийн хувиралд орсон бүсийг харуулсан. Филлитийн хувирал нь цооногийн гүнд бүхэлдээ судлын давтамж болон соронзон орны идэвхжилт, тархалт болон судлаар илэрсэн пиритийн эрдэсжилтийн өсөлттэй давхцаж байна. 51%-ийг Компани эзэмшдэг Улаан тусгай зөвшөөрлийн талбайд 700 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг төлөвлөснөөс UDH-02 цооногийг үргэлжлүүлэн 650 метрийн гүн хүртэл хувирлын системийг судлан өрөмдөх ажлууд багтана. Мөн өрөмдлөгийн хөтөлбөрөөр 200 метр бүхий хоёр гүехэн цооног өрөмдөнө. Үүнээс нэг нь кварц-турмалин брекчийн бүсийг судлах бөгөөд нөгөө нь геофизикийн аномаль бүхий шавар хувирлын бүсийг шалгахаар өрөмдөнө.

### Хойд Хөндий өрөмдлөг

Хойд Хөндий талбай нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн зүүн хойд бүсэд, Баян Хөндий ордоос 4 км-т оршдог. Өмнө нь эрлийн гүехэн өрөмдсөн цооног нь 2 г/т эрдэсжилт огтолсон бөгөөд энэ нь монционит агуулагч кварц брекч болон штокверкийн судлын структур бүхий сувагт багтсан. Хойд Хөндийн структурын гадаргын дээжлэлтээр 20 г/т алтны агуулга бүхий үр дүн илэрсэн. 2019 оны 3-р улиралд Хойд Хөндийд 253 метр өрөмдлөг хийсэн (AAD-38) нь гүндээ кварц брекч биет үргэлжилж буйг судлах зорилготой байсан. Сорьцлолтын үр дүнд 2 метрийн турш 0.25 г/т алтны агуулга бүхий гажилт байгааг тодорхойлсон. Алтны гажилт нь цооногт бүхэлд нь огтолсон кварц штокверкийн судлуудыг интервалуудтай холбоотойг илрүүлсэн.

### Төв Структурын Бүсийн хайгуулын өрөмдлөг

Төв Структурын Бүс нь Баян Хөндийн ордоос баруун хойд зүгт 800 метрт оршдог. Энэхүү бүс нь дөрвөн үе тунамал чулуулгаар хучигдсан тул илэрц нь хязгаарлагдмал юм. Урьд нь хийсэн хайгуул ба өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнд Баян Хөндий ордтой зэрэгцээ газрын гүнд структурын бүтэц байх магадлалтайг тодорхойлсон. 2019 оны 3-р улирлын хайгуулын өрөмдлөгөөр 200 метрийн гүнд IP геофизикийн аномалийг судалсан. Өрөмдлөгийн үр дүнд дунд болон их хэмжээний пиритийн тархалт бүхий туф ба порфирит кварцын андезит агуулсан цахиуржсан, цагаан гялтгануур галт уулын чулуулгийг огтолсон боловч алтны гажилт илрээгүй.

### Баян Хөндийн усны нөөцийн боловсруулалт

10-р сард Эрдэнэ Ресурсийн гэрээлэгч байгууллага нь усны нөөцийн эрэл-хайгуулын гидрогеологийн судалгаа болон өрөмдлөгийг хийж гүйцэтгэсэн:

- Баян Хөндий ордыг түшиглэн байгуулагдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрт шаардлагатай ус ашиглалтын нөөцийг тодорхойлох 6 цооног бүхий талбайг олж тогтоосон.
- Төлөвлөсөн хээрийн ангийн байрлалтай ойролцоо хоёр худгийг өрөмдөж гаргасан.
- 11 сарын эцэст ус ашиглалтын нөөцийг холбогдох байгууллагаар хэлэлцүүлж баталгаажуулж авна.

### 2019 оны 4-р улирлын техникийн хөтөлбөр:

2019 оны 4-р улиралд техникийн хөтөлбөрийг эхлүүлэх бөгөөд үр дүнд нь Баян Хөндий алтны ордын эцсийн ТЭЗҮ-г боловсруулахад шаардлагатай мэдээллийг бүрдүүлнэ.

- Эцсийн ТЭЗҮ-д багтах мэдээллийн хүрээнд уурхайн ханын налуугийн тогтвортой байдлыг судлахаар 750-800 метрийн геотехникийн хөтөлбөрийг эхлүүлсэн. Tetra Tech Inc нь урьдчилсан ТЭЗҮ-ийг

боловсруулахдаа геотехникийн нарийвчилсан үр дүн байхгүйгээс ханын налуугийн тогтвортой байдлыг уламжлалт төсөөлөлд тулгуурлан тооцоолсон. 4-р улирлын геотехникийн судалгаа нь ханын налууг илүү бодитоор тодорхойлох, ингэснээр хөрс хуулалтын харьцааг бууруулж, төслийн өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой.

- Металлургийн судалгаагаар эцсийн ТЭЗҮ-д багтах боловсруулах үйлдвэрийн зураглалд багтах боловсруулалт болон бутлагдах шинж чанарыг судална. Энэхүү судалгаанд: бутлагдах шинж чанар, чулуулгийн хатуулгын судалгаа, JK Drop test, бутлуурын ажлын индекс, элэгдлийн индекс, SMC бутлагдах чанарын судалгаа зэрэг багтана. Түүнээс гадна нүүрсэнд уусгах, цианидын хоргүйжүүлэх судалгаа болон ус шавхах параметрийн судалгааг хийж гүйцэтгэнэ.
- 11 сарын дундуур газрын дөт гүнд геотехникийн өрөмдлөгийн судалгааг хийж гүйцэтгэнэ. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Баян Хөндийн уурхай, боловсруулах үйлдвэр, барилга байгууламжуудын инженерийн загварчлалыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай хөрсний дээр, доорх нөхцөл байдлыг тодорхойлоход оршино.

#### 2019 оны 4-р улирлын хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөр:

- Улаан тусгай зөвшөөрлийн талбайд 700 метрийн өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: UDH-02 цооногийг үргэлжлүүлэн 650 метрийн гүн хүртэл өрөмдөх, түүнээс гадна 200 метрийн хоёр цооног шинээр өрөмдөхөөр төлөвлөсөн.
- Шинээр нээн илрүүлсэн Хар Морь талбайд алтны эрдэсжилт байгаа эсэхийг тодорхойлох өрөмдлөг хийхээс өмнө хөрсний болон чулуулгийн дээжийн нарийвчилсан сорьцлолт, геологийн зураглалын ажил хийнэ.
- Дүүргийн хэмжээний геофизикийн түүвэрлэлт, тайлал хийх хөтөлбөрийг төлөвлөж байгаа нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд шинэ өрөмдлөгийн бүсийг тодорхойлоход чиглэсэн. Энэхүү хөтөлбөр нь Баян Хөндий алтны ордтой ижил геофизикийн шинж чанар бүхий бүсүүдийг тодорхойлох, цаашид шинэ эрдсийн ордуудыг агуулсан байх боломжтой структууудыг илрүүлэхэд чиглэсэн.
- Бид засгийн газрын сонгон шалгаруулалтад оролцох, хөрөнгө оруулалт хийх зэргээр хэтийн төлөв бүхий тусгай зөвшөөрөл авах боломжуудыг судалсаар байна.

### **Хөндий Алтны Төслийн тухай**

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

2019 оны 10 сард Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн техникийн тайланг (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) танилцуулсан бөгөөд энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндий, Алтан Нар ордын татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (“NPV5%”) алтны үнийг \$1,300 ам.доллар/унц байхаар төсөөлөхөд тус бүр \$97 сая ам.доллар, \$24 сая ам.доллараар тооцоологдсон. Баян Хөндий ба Алтан Нарын дотоод өгөөжийн түвшинг (“IRR”) тус бүр 90%, 42% гэж тооцоолсон. Урьдчилсан ТЭЗҮ-д 0-7 жилд Баян Хөндий ордыг ашиглах ба 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 61,000 унц алтыг илээр олборлох, 7-10 жилд Алтан Нар ордыг ашиглан, 3.46 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 48,000 унц алт олборлохоор төлөвлөж байна. Баян Хөндий ордод уламжлалт нүүрсэнд уусгах боловсруулах үйлдвэрийг байгуулахаар төлөвлөсөн. 2019 оны 8-р сард Баян Хөндий

ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд компани 2021 оноос эхлэн үйлдвэрлэл эхлүүлэхээр төлөвлөж байна.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоололд боломжит нөөц агуулсан. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл ихтэй. Эдийн засгийн үр ашиг багатай геологийн нөөцийг үйлдвэрийн нөөц, эдийн засгийн тооцоололд багтаахгүй.

### Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)–ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

### Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

## Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

## Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>